



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр дүнг тооцоогүй, төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг баталж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

Аудитын дүгнэлтээс, 2019 он

“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

1. Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт
2. Аудитын ерөнхий дүн
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгүүд
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай шинээр эхлэх болон шилжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт
5. Хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийн өөрчлөлт
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлт
7. Худалдан авах ажиллагаа
8. Орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудын хийсэн аудитын дүн
9. Захиалагч болон үнэлгээний хорооны үйл ажиллагаа
10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл
11. 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан боловч хэрэгжээгүй төслүүд
12. 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан ч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ (тоо, байршлаар)
13. 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний судалгаа
14. 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ (тоо, байршлаар)
15. Захиалагч ба гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага
16. Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын хяналт
17. Нийгмийн салбарын нийгэм, эдийн засгийн үр ашиг
18. Он дамжин хэрэгжиж буй төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийн судалгаа
19. Аудитын шалгалтын мөрөөр хийгдсэн үйл ажиллагаа
20. Аудитын зөвлөмж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс

Утас: 51-263813

Факс: 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

<http://audit.mn/>



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ




Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээний тоо 2 дахин, санхүүжих дүн 81.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО




Шинээр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга барих зэрэг нийгмийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхүү чиглэгдсэн.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ



2018 онд 2,159.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 749 төсөл, арга хэмжээнд 683.3 тэрбум төгрөг, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 82.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор УИХ-аас баталсан.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САЛБАРААР



2018 онд нийгмийн салбарт 49.9 хувь буюу 340.9 тэрбум, дэд бүтцийн салбарт 29.7 хувь буюу 202.8 тэрбум, бусад салбарт 20.4 хувь буюу 139.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилжээ.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Аудитад Монгол Улсын 2018 оны төсөвт батлагдсан 749 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулав.

ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Тоо: **548**



Мөнгөн дүн: **84.6** тэрбум төгрөг



ГОЛ ЗӨРЧИЛ



Шинээр эхлүүлэх зураг төсөв шаардагдах **423** төсөл, арга хэмжээний **80.6** хувийг хуулийн шаардлага хангаагүй байхад баталсан.



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулсан байдал: **49** хувь

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

- Хэрэгжээгүй: **71** төсөл, арга хэмжээ
- Хэрэгжилт дутуу: **58** төсөл, арга хэмжээ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2018 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



Төрийн үйлчилгээний 6 барилга



154 ширхэг худаг



3968 суудалтай 7 сургууль



10 сумын 150 км 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл



170 ортой 5 дотуур байр



11 халаалтын зуух



1580 ортой 13 цэцэрлэг



6.2 км дулааны шугам, сүлжээний өргөтгөл



60 ортой 5 эмнэлэг



23.7 км кабель шугам



1050 суудалтай 2 соёлын төв



248.7 км хатуу хучилттай автозам



4199.7 м.кв талбайтай 1 спорт заал



793.4 урт (метр) гүүр, гүүрийн байгууламж



Аврах гал унтраах ангийн 3 барилга



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон баримт бичгүүд хоорондоо уялдахгүй байна.

Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр



Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон баримт бичгүүдэд тусгагдаж батлагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй орхигдож, чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээ батлагдах эрсдэл үүссэн байна.

2018 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫГ БАТАЛСАН БАЙДАЛ

2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ: Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд төсвийн хязгаарт тусгагдаагүй 6.0 тэрбум, төсвийн хязгаараас давуулж 269.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардлыг баталжээ. Үүнд:

ТӨСВИЙН ХЯЗГААРТ ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ ТУСГАГДААГҮЙ:

- ЕТГ-ын даргын багцад 770.7 сая
- УИХ-ын даргын багцад 1,913.3 сая
- ҮХ-ийн цэцийн даргын багцад 340.0 сая
- Улсын Ерөнхий прокурорын багцад 452.0 сая
- ГХ-ны сайдын багцад 1,800.0 сая
- Улсын Ерөнхий аудиторын багцад 500.0 сая
- АТГ-ын даргад 195.6 сая

НИЙТ 6 ТЭРБУМ ТӨГРӨГ

ТӨСВИЙН ХЯЗГААРААС ДАВУУЛАН:

- ЗГХЭГ-ын даргын багцад 8,784.9 сая
- ХЗДХ-ийн сайдын багцад 20,388.2 сая
- БОАЖ-ын сайдын багцад 61.5 сая
- БСШУСС-ын сайдын багцад 186,220.5 сая
- ХНХ-ын сайдын багцад 11,491.0 сая
- ЭХ-ний сайдын багцад 10,994.3 сая
- БХБ-ын сайдын багцад 31,435.3 сая

НИЙТ 269.4 ТЭРБУМ ТӨГРӨГ



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ШИНЭЭР ЭХЛЭХ БОЛОН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

2018 ОНД ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖҮҮЛЭХ	749 төсөл, арга хэмжээ	84.8% Шинээр хэрэгжих	Төслийн тоо: 635 Төсөвт өртөг: 1,104.6 тэрбум төгрөг
		15.2% Шилжих	Төслийн тоо: 114 Төсөвт өртөг: 1055 тэрбум төгрөг

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ТӨСЛИЙН ТОО



2018 ОНД САНХҮҮЖИЛТ ТӨЛӨВЛӨГДӨӨГҮЙ ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС

Төсөл, арга хэмжээ		Төсвийн ерөнхийлөн захирагч	Хэрэгжиж эхэлсэн он	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)
	Булган аймгийн Булган сумын 640 суудалтай сургуулийн барилга	БСШУСС	2012	4.2
	Өвөрхангай аймгийн Хужирт сумын 75 ортой цэцэрлэгийн барилга		2015	1.1
	ДЦС 4-өөс У-18 хүртэлх (Москва хорооллын урд тал хүртэл) 4.2 км, Ф800 голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил (УБ, БГД)	ЭХС	2014	17
	УБ, СХД-ийн Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг Москва хорооллын арын далангаар явуулж, Өнөр хорооллын 33 дугаар байрны арын замтай холбох 1 км автозамын барилгын ажил	ЗТХС	2014	7.9



Төсвийн хөрөнгө оруулалтын шилжих төсөл, арга хэмжээг орхигдуулж баталснаас он дамжих барилгын тоо нэмэгдэх, гүйцэтгэл удаашрах эрсдэлийг дагуулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Он дамжин хэрэгжиж байгаа 21 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2018 оны төсөвт анх баталснаас өөрчлөгдөж батлагджээ.



Төсөвт өртгийн өсөлт

Төслийн тоо: **16**
Мөнгөн дүн: **28.8 тэрбум төгрөг**

Төсөвт өртгийн бууралт

Төслийн тоо: **5**
Мөнгөн дүн: **1.8 тэрбум төгрөг**

ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДСЭН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

(сая төгрөг)

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсвийн тухай хуульд тусгагдсан төсөвт өртөг		Төсөвт өртгийн зөрүү
	2018 онд	2017 онд	
Аврах гал унтраах ангийн барилга (УБ, Багахангай дүүрэг)	1,820.9	1,250.0	570.9
Дэлхийн зөн Олон улсын байгууллагын тусламжийн Монголын талын хөрөнгө (улсын хэмжээнд)	14,000.0	8,000.0	6,000.0
Япон Улсын Өвсний үндэс хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө (улсын хэмжээнд)	10,700.0	6,200.0	4,500.0
Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн Монголын талын хөрөнгө (УБ)	12,900.0	2,300.0	10,600.0
БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн Монголын талын хөрөнгө (1 цэцэрлэг, 21 сургууль)	5,000.0	1,000.0	4,000.0
Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудалтай (УБ, СБД, Монгол-Оросын хамтарсан 3 дугаар дунд сургууль)	4,268.2	3,988.5	279.7
Сургуулийн барилга, 640 суудалтай (Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг)	4,486.0	4,265.0	221.0
Сургуулийн барилга, 320 суудалтай (Төв, Эрдэнэ сум)	2,960.0	2,668.7	291.3
Цэцэрлэгийн барилга, 150 ортой (Орхон, Баян-Өндөр сум)	1,439.8	1,250.0	189.8
Аймгийн хөгжимт драмын театрын барилга (Архангай, Эрдэнэбулган сум)	9,948.4	9,448.3	500.1
Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга (Увс, Улаангом сум)	3,406.2	2,995.8	410.4
Соёлын төвийн барилга (Өмнөговь, Манлай сум)	1,381.0	1,200.0	181.0
Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга (УБ, ХУД)	1,351.3	926.3	425.0
Сумын эрүүл мэндийн төвийн барилга (Хөвсгөл, Түнэл сум)	1,449.0	1,310.0	139.0
Сумын эрүүл мэндийн төв, 14 ортой (Баянхонгор, Баянцагаан сум)	1,183.5	820.0	363.5
Сумын эрүүл мэндийн төв, 10 ортой (Говь-Алтай, Цээл сум)	1,157.6	1,013.4	144.2
НИЙТ ДҮН	77,451.9	48,636.0	28,815.9




“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ТӨСЛҮҮД ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ



80.6%

2018 онд шинээр эхлүүлэхээр баталсан зураг, төсөв шаардлагатай **423** төсөл, арга хэмжээний **80.6 хувь** нь хуулийн шаардлага хангаагүй байжээ.



Зураг, төсөв нь баталгаажаагүй, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг Монгол Улсын төсвийн тухай хуульд тойм тоогоор батлуулдаг нь зураг, төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болжээ. Мөн зарим барилга, байгууламжийн нэмэлт ажлын зураг, төсвийг хууль батлагдахаас өмнө магадлал хийлгэж баталгаажуулалгүйгээр төсөвт өртгийг нь нэмэгдүүлж батлуулсан байна.

НЭМЭЛТ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСВИЙГ ХУУЛЬ БАТЛАГДАХААС ӨМНӨ МАГАДЛАЛ ХИЙЛГЭЖ БАТАЛГААЖУУЛАЛГҮЙГЭЭР ТӨСӨВТ ӨРТГИЙГ НЬ НЭМЭГДҮҮЛЖ БАТЛУУЛСАН ЗАРИМ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Төсөл, арга хэмжээний нэр	Байршил	Төсвийн ерөнхийлөн захирагч	Нэмэгдсэн төсөвт өртөг (сая төгрөг)
“Бага баян” ТӨҮГ-ын автозамын ажил	УБ, СБД	БХС	770.0
61-р сургуулийн спорт заалны барилга	УБ, ЧД		549.2
Цэцэрлэгийн барилга, 150 ортой	Орхон, Баян-Өндөр сум	БСШУСС	189.8
Аймгийн хөгжимт драмын театрын барилга	Архангай, Эрдэнэбулган сум		500.1
Сумын эрүүл мэндийн төв, 14 ортой	Баянхонгор, Баянцагаан сум	ЭМС	363.5



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА


Шинээр хэрэгжих **635** төсөл, арга хэмжээний гүйцэтгэгийг сонгон шалгаруулах **1055** худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга

81.4% Нээлттэй тендер шалгаруулалт

10.5% Харьцуулалт

6.6% Шууд гэрээ байгуулах

1.5% Хязгаарлагдмал тендер шалгаруулалт



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ

49%

Засгийн газраас 2018 оны худалдан авах ажиллагааг бүрэн хэмжээнд цахим систем ашиглан зохион байгуулахыг даалгасан боловч хэрэгжилт 49 хувьтай байна.

ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙГ ТОГТООЛГОХҮЙГЭЭР ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ТӨСЛҮҮД



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар зах зээлийн үнийг тогтоолгохгүйгээр худалдан авалт хийсэн байна.

Төсөл, арга хэмжээний нэр	Хүчин чадал	Байршил	Төсөвт өртөг (сая төгрөг)	Худалдан авах гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
Цэцэрлэгийн барилга	200	УБ, БЗД, 25-р хороо	2,500.0	“Үлэмж бит” ХХК
Сургуулийн барилга	500	УБ, БЗД, 10-р хороо	4,350.0	“Түмэн-Өргөө хаус” ХХК

ТӨСВӨӨС ХЭТРҮҮЛЭН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, НЭРИЙГ ӨӨРЧИЛСӨН ТӨСЛҮҮД



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Эрүүл мэндийн сайдын багц батлагдсан төсвөөс хэтрүүлэн гэрээ байгуулж, нэрийг өөрчилсөн байна.

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан дүн (сая төгрөг)
Албан тасалгааны тоног төхөөрөмж	10.9	12.8
Эмнэлгийн автомашин	26.5	31.0



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТАГТ ЭРХ ШИЛЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРУУДЫН ХИЙСЭН АУДИТЫН ДҮН



АЙМАГ,
НИЙСЛЭЛД
ИЛРҮҮЛСЭН
ЗӨРЧИЛ

Зөрчлийн тоо: **332**

₮ Мөнгөн дүн: **43.5 тэрбум төгрөг**



Алдаа, зөрчлийн мөнгөн дүн хамгийн өндөр 3 аймаг

Хөвсгөл (10.6 тэрбум төгрөг)

Дорнод (8.1 тэрбум төгрөг)

Говь-Алтай (4.7 тэрбум төгрөг)



Алдаа, зөрчлийн тоо хамгийн өндөр 3 аймаг


Хэнтий (138)

Архангай (24)

Өвөрхангай (20)

АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ АЛДАА, ЗӨРЧИЙН ТОО, МӨНГӨН ДҮН

(Тэмдэглэгээ: ТБ₮-тэрбум төгрөг)



ЗӨРЧИЛД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

12 зөрчлийг нөхөн төлүүлэх **0.6 тэрбум төгрөг**ийн төлбөрийн акт

156 зөрчлийг арилгуулах **20.8 тэрбум төгрөг**ийн албан шаардлага

160 зөрчлийг арилгуулах **22.6 тэрбум төгрөг**ийн зөвлөмж

Зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах **4 санал**



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗАХИАЛАГЧ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Захиалагч нь үнэлгээний хорооны үйл ажиллагаа, дүгнэлтийг хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулаагүй байна.



114

Үнэлгээний хороог хугацаа хоцорч байгуулсан төсөл, арга хэмжээ

102

Хугацаа хоцорсон дундаж хоног

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО БАЙГУУЛСАН ХУГАЦАА (хоног, төслийн тоо)

№	Захиалагч	Төсөл, арга хэмжээний тоо	Хугацаа хоцорсон төсөл, арга хэмжээ	
			тоо	хоног (дунджаар)
1	Эрчим хүчний яам	7	3	60
2	Байгаль орчин аялал, жуулчлалын яам	8	2	91
3	Барилга, хот байгуулалтын яам	4	4	151
4	Зам тээврийн хөгжлийн яам	12	11	75
5	Эрүүл мэндийн яам	35	35	116
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	59	59	123
НИЙТ		120	114	102.7



Тендерт оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүдээс 2018 онд гаргасан гомдлын тоо

1187 Сангийн яаманд

198 Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт

61 Шүүх байгууллагад



Сангийн яам иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирсэн гомдлыг шийдвэрлэсэн байдал

53.8% Тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх

31.9% Гомдол үндэслэлгүй

14.3% Тендерийг хүчингүй болгох



Төсвийн ерөнхийлөн захирагчдын гаргасан зөрчлүүд

Хуулийн шаардлага хангаагүй гүйцэтгэгч шалгаруулж, хууль, журмын дагуу ажиллаагүй үнэлгээний хорооны гишүүдэд төсвийн ерөнхийлөн захирагч нар хариуцлага тооцож, арга хэмжээ аваагүй.

Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчин зарим төсвийн ерөнхий захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ангилал, зориулалтыг өөрчилсөн.

Зарим төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хэмнэлтээс нэмэлт гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ



2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл (дунджаар)

72.6%

ГҮЙЦЭТГЭЛ (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь
Гадаад харилцааны сайд	3	100
Авлигатай тэмцэх газрын дарга	1	100
Үндсэн хуулийн цэцийн дарга	1	99.8
Монгол Улсын Ерөнхий прокурор	4	99.7
Монгол Улсын Ерөнхий аудитор	1	99.6
Хууль зүй, дотоод хэргийн сайд	40	99.5
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	3	97.9
Монгол Улсын Шадар сайд	12	95.2
Эрчим хүчний сайд	20	93.2
Батлан хамгаалахын сайд	4	92.6
Монгол Улсын Их Хурлын дарга	1	88.9
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	25	87.7
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	32	83.1
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	5	77.8
Зам тээврийн хөгжлийн сайд	64	76
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	32	72.3
Монгол Улсын Ерөнхий сайд	8	72
Барилга, хот байгуулалтын сайд	78	70.7
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	325	69.1
Сангийн сайд	14	63.4
Байгаль орчин аялал, жуулчлалын сайд	13	56.7
Эрүүл мэндийн сайд	63	52.4



Улсын төсвийн 22 ерөнхийлөн захирагчаас 9-ийнх нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 80-аас доош хувьтай байна.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2018 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДСАН БОЛОВЧ ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСЛҮҮД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт **749** төсөл, арга хэмжээний **9.5 хувь** нь хэрэгжээгүй.



ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

71 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ 212 тэрбум төгрөг	САНХҮҮЖИХ ДҮН 57.8 тэрбум төгрөг
---------------------------------	---	--

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙН ШАЛТГААН

39.4%	Худалдан авах ажиллагаа хүчингүй болсон
19.8%	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй
8.5%	Худалдан авах ажиллагаа хийгдсэн боловч гэрээ байгуулагдаагүй
7%	Гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй
1.4%	Шаардлагагүй арга хэмжээг төлөвлөсөн
23.9%	Бусад шалтгаан

2018 ОНД ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

(сая төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Эзлэх хувь	Санхүүжих дүн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	31	43.7	25,865.8
Барилга, хот байгуулалтын сайд	11	15.5	6,729.3
Зам тээврийн хөгжлийн сайд	9	12.7	7,761.4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	8	11.3	2,890.0
Эрүүл мэндийн сайд	4	5.6	6,671.8
Сангийн сайд	3	4.2	5,990.0
Монгол Улсын Ерөнхий сайд	1	1.4	829.5
Монгол Улсын Шадар сайд	1	1.4	100.0
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	1	1.4	750.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	1.4	30.0
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	1.4	143.1
НИЙТ ДҮН	71	100.0	57,761.0



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний дийлэнх хувь нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад байна.




“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДСАН Ч ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (тоо, байршлаар)



Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээг байршлаар авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн их буюу 40 төсөл, арга хэмжээ байна.



АРХАНГАЙ

- Сургуулийн дотуур байрны барилга, Хангай сум

БАЯН-ӨЛГИЙ

- Цэцэрлэгийн барилга, Бугат сум

БАЯНХОНГОР

- Соёлын төвийн барилга, Гурван булаг сум
- Мандалын голын төмөр бетон гүүр, Галуут сум

БУЛГАН

- Сургуулийн барилгын өргөтгөл, Тэшиг сум

ГОВЬСҮМБЭР

- ЖДҮ-ийг дэмжих төвийн барилга
- Нэгдсэн эмнэлгийн барилга, Сүмбэр сум

ДАРХАН-УУЛ

- Авто замын нүхэн гарц, Дархан сум

ДОРНОД

- Сүү, сүү бүтээгдэхүүний үйлдвэр

ЗАВХАН

- ЗДТГ-ын барилга, Их-Уул сум

ХӨВСГӨЛ

- Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, Мөрөн сум

ОРХОН

- Инженерийн шугам сүлжээ, Баян-Өндөр сум
- Сургуулийн барилга, Баян-Өндөр сум

- Соёлын төвийн барилга, Баян-Өндөр сум

- Авто замын өргөтгөл, Баян-Өндөр сум

ӨМНӨГОВЬ

- Агуулахын барилга, Ханхонгор сум
- Гаалийн албан хаагчдын орон сууц, Ханбогд сум

- Дотуур байр, Гурвантэс сум

СҮХБААТАР

- Ахмадын өргөөний тоног төхөөрөмж, Мөнххаан сум
- Сургуулийн дотуур байр, Уулбаян сум

СЭЛЭНГЭ

- Цэцэрлэгийн барилга, Мандал сум
- Орхон голын гүүр, Орхонтуул сум

УВС

- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, Улаангом сум
- Гашууны голын төмөр бетон гүүрийн засвар, Улаангом сум
- Гүний худаг, Улаангом сум

ХЭНТИЙ

- Ханхэнтий чуулгын барилга, Хэрлэн сум

- Онон голын төмөр бетон гүүрийн засвар, Дадал, Баян-Адарга сум

УЛААНБААТАР

- Сургуулийн барилга, өргөтгөл: 7
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга: 1
- Цэцэрлэгийн барилга, өргөтгөл: 11
- Цахилгааны сүлжээ: 1
- Дулааны шугам сүлжээ: 3
- Ус зайлуулах шугам: 1
- Инженерийн шугам сүлжээ: 2
- Хүүхдийн тоглоомын талбай, сагсны талбай: 2
- Оюуны спортын ордны барилга: 1
- Авто зам: 3
- Гүний худаг: 5
- Эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөл: 3

УЛСЫН ХЭМЖЭЭНД

- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний Монголын талын хөрөнгө: 2
- Гаалийн газар, хороодын барилгын өргөтгөл, шинэчлэлт
- Суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДАЖ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 749 төсөл, арга хэмжээний 7.9 хувь нь дутуу хэрэгжсэн.



ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

НИЙТ **58** ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ **204 тэрбум төгрөг**

САНХҮҮЖИХ ДҮН **50.6 тэрбум төгрөг**



ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ШАЛТГААН

62.3% Гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүй

24.2% Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа

4.5% Санхүүжилт хугацаандаа олгогдоогүй

6% Зураг, төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийгдсэн

3% Гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүй

2018 ОНД ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)
(сая төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Эзлэх хувь	Санхүүжих дүн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	52	89.7	44,434.4
Барилга, хот байгуулалтын сайд	4	6.9	5,482.4
Зам тээврийн хөгжлийн сайд	1	1.7	300.0
Монгол Улсын Ерөнхий сайд	1	1.7	103.0
НИЙТ ДҮН	58	100.0	50,319.8



2018 онд дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний дийлэнх нь буюу 89.7 хувь нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад байна.




“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДАЖ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (тоо, байршлаар)



Улаанбаатар хотод хамгийн их буюу дутуу хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээ байна. Цаашилбал, Говь-Алтай, Архангай, Баян-Өлгий аймгууд удаалж байна.



АРХАНГАЙ

- Цэцэрлэгийн барилга (Хангай сум)
- Соёлын төвийн барилга: 3 (Цэцэрлэг, Өлзийт, Хашаат сум)
- Эрүүл мэндийн төвийн барилга (Цахир сум)

БАЯН-ӨЛГИЙ

- Дотуур байрны барилга (Дэлүүн сум)
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга (Өлгий сум)
- Эмнэлгийн барилга (Цэнгэл сум)
- Эрүүл мэндийн төвийн барилга (Алтан цөгц сум)
- Хүүхдийн эмнэлгийн барилга (Өлгий сум)

БАЯНХОНГОР

- Хүүхдийн эмнэлгийн барилга (Баянхонгор сум)

ГОВЬ-АЛТАЙ

- Сумын төвлөрсөн зуухын барилга (Жаргалан сум)
- Сургуулийн барилга, өргөтгөл, спорт заал: 3 (Есөнбулаг, Дарви, Чандмань сум)
- Цэцэрлэгийн барилга: 2 (Эрдэнэ, Халиун сум)

ДАРХАН-УУЛ

- Төрөх эмнэлгийн барилга (Дархан сум)

ДОРНОГОВЬ

- Төрөх эмнэлэг (Сайншанд сум)

ОРХОН

- Цэвэрлэх байгууламжийн өргөтгөл (Баян-Өндөр сум)

- Цэцэрлэгийн барилга (Баян-Өндөр сум)

ӨВӨРХАНГАЙ

- Соёлын төвийн барилга (Бүрд сум)
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
- СҮХБААТАР
- Мэдээлэл, харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв (Дарьганга сум)
- Цэцэрлэгийн барилга (Эрдэнэцагаан сум)

СЭЛЭНГЭ

- Цэцэрлэгийн барилга: 4 (Шаамар, Мандал, Алтанбулаг, Орхонтуул сум)

ТӨВ

- Цэцэрлэгийн барилга (Жаргалант сум)
- Эрүүл мэндийн төвийн барилга (Заамар сум)

УВС

- Цэцэрлэгийн барилга (Улаангом сум)
- Соёлын төвийн барилга (Зүүнговь сум)

ХОВД

- Цэцэрлэгийн барилга (Мянгад сум)
- Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төв (Жаргалант сум)

ХӨВСГӨЛ

- Цэцэрлэгийн барилга: 2 (Түнэл, Цэцэрлэг сум)
- Эмнэлгийн барилга (Мөрөн сум)
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Галт сум)

УЛААНБААТАР

- Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөл
- Үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө
- Авто замын гүүр, авто зогсоол
- ХААИС-ын хичээлийн байрын барилга
- 61-р сургуулийн спорт заалны барилга
- Сургуулийн барилгын өргөтгөл
- Цэцэрлэгийн барилга: 5
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторийн барилга
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга
- Зооноз өвчин судлалын үндэсний төвийн агуулахын байрын барилга

УЛСЫН ХЭМЖЭЭНД

- Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгын угсралтын ажил
- Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн цогцос хадгалах байрны гадна шугам сүлжээний ажил
- Гадна ариутгах татуурга, гадна дулаан хангамж, гадна усан хангамжийн ажил
- Гадна цахилгаан хангамж, гадна холбооны ажил
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн ариутгалын тасаг
- Сумын төвүүдийн шинэчлэлт төсөл



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗАХИАЛАГЧ БА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮД:

Барилга угсралтын ажил гүйцэтгэгч зарим компани гэрээний үүргээ биелүүлээгүй, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэхгүй байна. Үүнд:



- Захиалагч болон ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс ажил гүйцэтгэх боломж олгоогүй.
- Зарим ажлыг гүйцэтгээгүй эсвэл зураг, төсвийн дагуу барилга угсралтын ажлыг гүйцэтгээгүй байхад хариуцлага тооцоогүй.
- Гэрээний хугацааг сунгаагүй.

ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНДАА БАГТАЖ ДУУСГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Төсөл, арга хэмжээ	Хүчин чадал	Байршил	Төсөвт өртөг (сая төгрөг)	Барилга угсралтын ажил гүйцэтгэгч	Ажлын гүйцэтгэл %
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦ					
Цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн үерийн хамгаалалтын барилга байгууламж далангийн барилга угсралтын ажил	900 м	Орхон аймаг, Эрдэнэт хот	429.5	“Ээлт өлгий” ХХК	90
Төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур, 2 ширхэг биоцөөрөм барих ажил	-	УБ	8,519.1	“Сайн констракшн” ХХК	80
Үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, ИШС-ний зураг төслийн ажил	-	Багануур	788.0	“Мон энерги” ХХК	30
Сумын төвлөрсөн зуухны барилга угсралтын ажил	-	Говь-Алтай, Жаргалан	796.5	“Эн Ар Жи Эм” ХХК	70
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН БАГЦ					
Цэцэрлэгийн барилга	150 ортой	Орхон, Баян-Өндөр сум	1,439.8	-	95
	75 ортой	Сэлэнгэ, Шаамар сум	1,287.6	-	86
	100 ортой	УБ, БЗД, 25 дугаар хороо	721.3	-	81.5
	50 ортой	Сэлэнгэ, Алтанбулаг сум	750.0	-	88
	200 ортой	УБ, БЗД, 25 дугаар хороо	2,500.0	-	50.2
	50 ортой	Төв, Жаргалант сум	1,000.0	-	82.6
	75 ортой	Баян-Өлгий, Ногооннуур сум	500.0	-	85
	100 ортой	Говь-Алтай, Эрдэнэ сум	900.0	-	72.5



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТ

Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хангалтгүй байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ



САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.3-т заасныг үндэслэн Сангийн яамнаас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 19 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж, чиглэл өгчээ.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ДОТООД ХЯНАЛТ



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Дотоод аудитын нэгж 2018 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланд Сангийн сайдын 2017 оны 363-р тушаалд үндэслэн шалгалт хийж, дүгнэлт гаргаагүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” (Сангийн сайдын 2017 оны 363-р тушаал)

3.5 дахь заалт: “Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг дотоод аудит (дотоод аудитын нэгжгүй байгууллагын хувьд өөрийн байгууллагын дотоод аудит)-аар хянуулж, холбогдох дүгнэлтийн хамт ирүүлнэ”.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайлант оны худалдан авах ажиллагааны тайланд дотоод аудит хийх боломжгүй болгожээ.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.5 дахь заалтыг 2018 оны 281 дүгээр тушаалаар шинэчлэн батлахдаа хассан нь Төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайлант оны худалдан авах ажиллагааны тайланд дотоод аудит хийх боломжгүй болгосон байна.





“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

НИЙГМИЙН САЛБАРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ

Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна. Үүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбараар төлөөлүүлэн авч үзвэл:



**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙД**

- Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаагүй;
- Салбарын хэмжээнд ашиглаж байгаа барилга байгууламжийн насжилт, чанар байдлын судалгааг бүрэн хийгээгүй;
- Хүчин чадлыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тооцсон нэгдсэн судалгаа байхгүй.

**ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААС
БИЙ БОЛОХ
ҮР АШГИЙГ
ТООЦООГҮЙ.**



БОДИТ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦЭХГҮЙ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, АШИГЛАЛТЫН ҮРГҮЙ ЗАРДАЛ ГАРАХ ЭРСДЭЛ ҮҮСГЭСЭН.

ЖИШЭЭ: Сургуулийн хичээлийн байрын барилга, өргөтгөлийн хэрэгцээ их байгаа ч бодит хэрэгцээнд үндэслэн тооцохгүйгээр 2018 онд Дундговь аймгийн Дэрэн суманд 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдаж байна. Тус сумын сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд нийт 234 сурагч (ахлах ангигүй) суралцаж байгаа бөгөөд суурь боловсрол эзэмшиж байгаа 98 сурагч (6-9 дүгээр анги), сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 107 хүүхэд (2-5 насны) байна.



ТҮҮВРИЙН АРГААР ДОТУУР БАЙРНЫ 5 БАРИЛГЫГ СОНГОЖ ҮЗЭХЭД ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ БОДИТОЙ ТООЦООГҮЙ БАЙНА.

ЖИШЭЭ: Хэрэгцээ, шаардлагаас илүү хүчин чадалтай дотуур байр баригдаж байгаа сумд:

- Хэнтий аймгийн Баян-Овоо сум
- Өвөрхангай аймгийн Тарагт сум
- Хөвсгөл аймгийн Түнэл сум

Хэрэгцээ, шаардлагаас бага хүчин чадалтай дотуур байр баригдаж байгаа сум:
- Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын 6-аас дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний явцыг судалж үзэхэд, анх баталсан хугацаандаа хэрэгжүүлээгүйгээс төсөвт өртөг нэмэгдэж, хөрөнгийн болон цаг хугацааны хувьд үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгджээ.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН СУДАЛГАА



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 22 төслийг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс төсвөөс гарсан илүү зардал

35.9
тэрбум төгрөг

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АНХ БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙГ 2018 ОНЫ ТӨСӨВТ ӨРТГИЙН ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

(сая төгрөг)

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хүчин чадал	Байршил	Шинэчлэгдсэн төсөвт өртөг	Анх батлагдсан төсөвт өртөг	2018 оны төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнэ /эхлэх үеийн үнэ цэнэ/	Өнөөгийн үнэ цэнэ төсөвт өртгийн зөрүү
Их сургуулийн барилга: 1	УБ, ХУД, ХААИС-ийн 2-р байр		6,634.9	900.0	3,847.7	2,947.7
	960 суудал	Баянхонгор, Баянхонгор сум	5,274.0	3,200.0	4,740.7	1,540.7
	640 суудал	Булган, Булган сум	4,300.0	2,000.0	3,865.2	1,865.2
	960 суудал	Говь-Алтай, Есөнбулаг сум	5,426.9	3,200.0	4,878.1	1,678.1
Сургуулийн барилга: 8	640 суудал	Дорнод, Баян-Уул сум	3,958.7	1,990.0	3,558.4	1,568.4
	320 суудал	Хөвсгөл, Улаан-Уул сум	3,238.0	1,800.0	2,910.6	1,110.6
	220 суудал	Хөвсгөл, Цагаан-Үүр сум	2,023.5	1,400.0	1,837.1	437.1
	640 суудал	Орхон, Баян-Өндөр сум	4,486.0	2,200.0	4,154.1	1,954.1
320 суудал	Төв, Эрдэнэ сум	2,960.0	1,800.0	2,660.7	860.7	
Сургуулийн дотуур байрын барилга: 1	150 ор	Дархан-Уул, Шарын гол сум	1,502.0	750.0	1,350.1	600.1
Спорт заалын барилга: 1		УБ, ЧД, 61 дүгээр сургууль	1,599.2	550.0	1,437.5	887.5
Хөгжимт драмын театрын барилга: 2		Архангай, Эрдэнэбулган сум	9,948.4	5,100.0	8,942.3	3,842.3
	800 суудал	Завхан, Улиастай сум	9,960.0	3,000.0	5,776.0	2,776.0
		Увс, Улаангом сум	3,406.2	700.0	1,975.3	1,275.3
Соёлын төвийн барилга: 3		Өмнөговь, Манлай сум	1,381.0	650.0	1,241.3	591.3
	400 суудал	Өвөрхангай, Уянга сум	1,402.0	450.0	665.9	215.9
Чуулгын барилга: 1		Хэнтий, Хэрлэн сум	8,353.7	3,500.0	4,844.5	1,344.5
	1000 суудал	УБ, ЧД	9,019.9	2,561.3	4,712.4	2,151.1
	1000 суудал	УБ, БЗД	8,229.3	2,561.3	4,299.4	1,738.1
Спорт цогцолбор: 5	700 суудал	УБ, Налайх дүүрэг	10,397.9	1,885.2	5,432.4	3,547.2
	2200 суудал	Дархан-Уул, Дархан сум	21,443.0	11,041.0	12,435.2	1,394.2
	500 суудал	Ховд, Манхан сум	2,458.0	600.0	2,209.4	1,609.4
НИЙТ			105,487.7	51,838.8	87,774.3	35,935.5



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ШАЛГАЛТЫН МӨРӨӨР ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ӨМНӨХ ОНД ХИЙСЭН АУДИТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Өмнөх аудитаар долоон байгууллагад 20 гаруй албан шаардлага, мөн 20 гаруй зөвлөмж хүргүүлж, 6 акт тогтоосон.

ХАМААРАХ ЭТГЭЭД:

- УИХ-ын Төсвийн байнгын хороо
- Ерөнхий сайд
- Сангийн сайд
- Барилга, хот байгуулалтын сайд
- Зам тээврийн хөгжлийн сайд
- Эрчим хүчний сайд
- Төсвийн ерөнхийлөн захирагч нар



20.7 тэрбум төгрөгийн 27 албан шаардлага



110.2 сая төгрөгийн 6 акт



21 зөвлөмж



Өмнөх онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын аудитаас өгсөн дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй төдийгүй зөрчлүүд давтагдан гарсаар байна. Үүнд:

- Дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулаагүй, Засгийн газраас баталсан төсвийн хязгаарыг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг саналд тусган өргөн барьсан хэвээр байна.
- Захиалагч ажлын гүйцэтгэлийг зураг, төсөвтэй тулган шалгаж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулдаггүй, төсөл, арга хэмжээг хугацаанд нь ашиглалтад оруулахад шаардлага тавьж ажилладаггүй, зөрчил гаргасан гүйцэтгэгчид хариуцлага тооцдоггүй.
- Ажлын гүйцэтгэлийг бодитой тооцоогүйгээс гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгосон буруутай албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй.



“МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХААРЛАД ТОЛИЛУУЛАХ НЬ:

- УИХ-аас Монгол Улсын төсвийн тухай хуулийг батлах явцад гишүүдийн саналаар салбарын саналд тусгагдаагүй, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдээгүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг батлуулж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд илэрсэн алдаа, зөрчил жил бүр давтагдаж, аудитаар тэдгээрийг арилгуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч нар хэрэгжүүлэхгүй байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР САНГИЙН ЯАМ

САНГИЙН САЙДАД:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааг аргачлалын дагуу сонгож, Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан төсөл, арга хэмжээг Засгийн газарт хүргүүлж байх;
- Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг оройтож зарласан, ажил гүйцэтгэх гэрээг барилгын улирал дуусах үед байгуулснаас шалтгаалж урьдчилгаа төлбөрийн баталгаа болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын санхүүжилт хүссэн албан бичигт үндэслэн санхүүжилтийг олгох, олгосон санхүүжилтийг барьцаа хөрөнгийн болон техник хяналтын зардлын дансанд байршуулдгийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх;
- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн ажлын хариуцлагыг сайжруулж, барилга байгууламжийг дутуу орхих, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгах, хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгож, улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тооцох арга зүйгээр хангаж ажиллах.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн хяналт хийх зардлын дансыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр үүсгэж, хяналт тавьж ажиллах;



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд илэрсэн алдаа, зөрчил жил бүр давтагдаж, аудитаас тэдгээрийг арилгуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч нар хэрэгжүүлэхгүй байгаад анхаарал хандуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Төсвийн тухай хуульд заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан, хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг батлуулах, худалдан авах ажиллагааг оны эхний хагаст багтаан зохион байгуулах талаар холбогдох, хууль, журамд өөрчлөлт оруулах боломжийг судалж, шийдвэрлүүлэх;

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

- Улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг оновчтой тогтоож, хуулиар тодорхойлсон шаардлагыг бүрэн хангасан, эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр дүн нь тодорхойлогдсон арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдах төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;
- Хөрөнгө оруулалтын үе шат бүрд ажлын явц, гүйцэтгэлийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээ бүрээр газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулах, ажлын гүйцэтгэлийг зураг, төсөвтэй нь тулган шалгаж, гүйцэтгээгүй ажлыг хийлгэх, баталгаат хугацаанд үүссэн гэмтэл, согогийг засуулах зэрэг арга хэмжээг авах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг анхан шатны баримтаар тулган шалгаж, ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;
- Захиалагч барилга, байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлд зохиогчийн хяналт хийх гэрээг зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжтэй байгуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрээр дүгнэлт гаргуулан үр дүнг тооцож, санхүүжилтийг олгож байх;
- Улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, чанаргүй барилга, байгууламж барьсан аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар тогтоосон акт, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлэх.